

УЛСЫН ШАЛГАЛТ - 2023

МОНГОЛ ХЭЛ

IX АНГИ

Аймаг/дүүрэг:

Сум:

Сургууль:

Анги: Бүлэг:

Овог:

Нэр:

САНАМЖ, ЗӨВЛӨГӨӨ

- Эхийг анхааралтай уншаад, даалгавруудыг гүйцэтгээрэй.
- Шалгалт 80 минутад үргэлжлэх тул цагаа сайтар төлөвлөж, зөв хуваарилан, бүх даалгаврыг гүйцэтгээрэй.

Газар шороо мину

Би гэдэг хүн хөдөө явж үзээгүйгээ хүнээс нууж явдаг хотын унаган охин. ” Хөдөөгийн амьдрал” гэдгийг багадаа уншиж өссөн ном зохиол мөн бусдын яриагаар л төсөөлдөг байлаа. Хөдөөгийн гэх тодотгол бусдын адил надад “хуучирсан” “хоцрогдсон” гэдэг ойлголттой дүйдэг байсныг нуух юун. Өнгөрсөн өвөл Өвөрхангай аймагт очиж ажиллах хэд хоногийн томилолт авсан юм. Тэгэхэд хотын амьдралаас холдож хэсэг зуур амсхийсэн минь хөдөөгийн сайханд амтших эхлэл байсан гэхэд болно. Харин саяхан аавын төрсөн нутаг руу аялах боломж гарсан юм.

Холын замд гарсан гурван машинаараа бид байгалийн элдэв сайхныг харж замдаа түр саатан цай цүү ууж явсаар олон зуун километрийн цаадах зорьсон нутагтаа ирлээ. Цэлийсэн уудам талыг нүд бэлчээн харж, нэг ч мод ургадаггүй нь их л сонин санагдсаар хотын давчуу сэтгэхүйгээр хучигдсан стресс маань алга болох шиг боллоо. Хээр тал гэж чухам ийм л газрыг хэлдэг байх даа хэмээн эрхгүй санагдаж, ёстой л цээж тавиун амьсгалмаар боллоо. Энэ бол миний аавын төрсөн газар, өвөө эмээгийн минь төрөлх нутаг Сүхбаатар аймаг билээ. Хоёр жилийн өмнө өвөөгийн дурсгалд зориулан бүтээсэн цагаан суварга руу хамгийн түрүүнд очлоо. Тэр ариун дагшин газарт Үүд овгийн үр хүүхдүүд бид сүү цагаагаа өргөн зан үйл үйлдэж, хүндэтгэл үзүүлээд цааш одлоо.

Уран зургаас л олж хардаг байсан Алтан Дарь Овооны бараа харагдаж эхэлмэгц сэтгэл хөдөлж, гайхан биширч явлаа. Энэ бол миний зорьж ирсэн хамгийн гол зүйл. Сүхбаатар аймгаар овоглодог хүн бүр энэ хайрхнаа тахин шүтэж, амьдрал ахуйгаа даатгадаг билээ. Овооны тахилга үүрээр эхэлж, тал бүрээс ганган дээл хувцастай хүмүүс цуглаж эхлэв. Овоогоо эргэж, замдаа сунаж мөргөн залбирсаар гурвантаа тойроход сая зорилго биелж бусдын адил сэтгэл уужирлаа. Үнэхээр хүний хийморь гэдэг байгаль дэлхийтэйгээ нарийн учгаар холбогдож байдаг гэлтэй.

Бидний дараагийн маршрут бол алдарт Шилийн Богд байв. Энэ сүрлэг Богд уул хагас тойрог хэлбэртэй, оройдоо овоо тахилгатай, үнэхээрийн бахдан бишрэхээс аргагүй хайрхан байлаа. Өмнө нь Алтан овоогоо доороос харсан бол энэ удаад уулан дээрээс эргэн тойрныг харахад үгээр хэлэхийн аргагүй бахдам сайхан байсан юм. Энд тэнд сөнөсөн галт уулын өвөрмөц тогтоцтой үлдцүүд яг л үлгэрийн оронд ирсэн мэт гайхам сонин мэдрэмж төрүүлж байлаа.

Хун чуулдгаараа цуутай Ганга нуурын хөвөөнд очиж нүд баясган хэсэг амарлаа. Нуурын цэнхэр мандал дээр арав гаруй хун үзэсгэлэнтэй нь аргагүй хөвж явна. Харийн нутгийн амьтны хүрээлэнгийн тэжээвэр хунг бодвол жинхэнэ байгалийн амьтан гэж ондоо юмаа. Санаж байснаас цөөхөн байсан ч тэр ховрын амьтныг алсаас харж чадсандаа би сэтгэл хангалуун байлаа. Ингээд холгүйхэн байдаг Оргихын булагт зочлов. Хааш хаашаа алд хэртэй газарт пор порхийх тэр булаг дуу авианы үелзлээр улам оргидог юм байна. Ингээд бид “Үлэмжийн чанар” дууг хэр чадлаараа дуулахад Оргихын булаг маань баярлан хөөрч улам ихээр оргиллоо. Байгаль эх амьд гэдэг юутай үнэн үг вэ?

Тал дунд газар руу орсон агуй байдаг гэж гадаадын хүнд хэлбэл нүдээр харахаас нааш итгэхгүй байх. Би ч гэсэн мянга сонссоноос нэг үзэхээр шийдэж, байгалийн тэрхүү гайхамшигийг харах эрхэм нэгэн зорилготой очсон билээ. Тал дунд хонхойж орсон тогоо шиг газрын яг голд нь хадтай хэсэг байх ба хүн орох нарийхан зайтай юм санж. Энэ бол талын агуйн үүд хаалга. Дотогш орлоо. Тас харанхуй, хүйтэн хоёр нэг л айдас төрүүлэм. Ямар нэгэн олон зуун жилийн нууц энд байх шиг, цаанаа л ер бусын мэдрэмж төрүүлж байлаа. Миний тооцоо зөв бурууг хэлж мэдэхгүй юм, ямартай ч хорь орчим метр замыг намхан таазтай хэсгээр бөхийж явсны дараа агуйн жинхэнэ том хэсэг рүү орж явчлав. Энэ бол жинхэнэ гайхамшиг. Тааз нь болор шиг мөсөн талстаар дүүрэн байх бөгөөд голдоо яг л хүний гараар урласан мэт “тооно”-той. Газар доор ийм сонин ордон шиг агуй байна гэдэг үнэхээр сонин. Шилийн сайн эрчүүд хэдэн азарга адуу тууж ирээд нуудаг байсан гээд бодохоор хадаар хучигдсан тэрхүү газрын хөндий нэлээд том зайтай байгаа биз. Байгалийн сонин содон тогтоц гэж үнэхээр гайхаж баршгүй юм даа хэмээн шагширсаар аяллаа цааш үргэлжлүүлэв.

Төрсөн нутагтаа би таалагдсан гэдэгтээ итгэлтэй байна. Яагаад гэвэл төрсөн нутаг минь надад онцгой таалагдсан. Атга шороо нь хүртэл надтай хамааралтай тийм

сайхан нутаг. Буцах цаг боллоо, холын зам урд зурайна. Явахын өмнө би газраар нэг байх гоёмсог жижиг чулуунуудаас өөртөө дурсгал болгон авсан ч байрнаасаа хөдөлсөн чулуу гурван жил зовдог гэсэн үг санаанд бууж, цуглуулсан чулуун тоглоомуудаа тэнд нь орхихоор шийдлээ. Харин нүдэнд туссан Алтан Овоо шиг хэлбэртэй жижигхэн ганц чулууг авч хадгаллаа. Ингээд би өөрийн гэсэн хайрладаг нутагтай, шүтдэг уултай, биширдэг байгальтай, хүндэлдэг ард түмэнтэй, жинхэнэ Дарьганга охин болоод буцлаа.

Даалгавар 1. Зохиолч эхэд ямар асуудлыг дэвшүүлсэн бэ? 2 оноо

Зохиолчийн дэвшүүлсэн асуудал:

.....

.....

.....

.....

Даалгавар 2. Эхийн гол санааг илэрхийлж буй өгүүлбэрийг олж бичээд, яагаад гол санаа гэж бодож байгаагаа эхээс эш татан, өөрийн үгээр тайлбарлаарай. (3 оноо)

Эхийн гол санааг илэрхийлсэн өгүүлбэр:

.....

.....

.....

Тайлбар:

.....

.....

Дэвшүүлсэн асуудлын талаар үзэл бодлоо баримтад үндэслэн илэрхийлж, өөрийн санааг дүгнэн бичье.

Даалгавар 3. Дэвшүүлсэн асуудлын талаар үзэл бодлоо бичээрэй. Үзэл бодлоо илэрхийлэх үгсийг ашигласан, тодорхой, бодитой, асуудалтайгаа уялдаа холбоотой байхад анхаараарай. 2 оноо

Миний үзэл бодол:

.....

.....

.....

.....

.....

Даалгавар 4. Өөрийн үзэл бодлоо үнэ цэнтэй, чухал гэдгийг батлах, дэмжих баримтуудыг бичээрэй. 3 оноо

Баримт 1:

.....

.....

.....

Баримт 2:

.....

.....

.....

Засагч багш нарт:

Шалгалтын материалыг засаж оноожуулахаас өмнө засалт хийх багш нар бүгд материалыг уншиж, оноо өгөх нэгдсэн нэг ойлголттой болно.

Боломжтой бол засагч багш нар ажлаа хуваарилахдаа материалын тоог тэнцүүлж, таван багшид дөч дөчин материал гэх биш, бүх шалгуулагчийн 1-3-р даалгаврыг нэг багш, 4-7- даалгаврыг нэг багш, 8-р даалгаврыг гурван багш гэх мэтээр хуваарилах. Энэ нь шалгалтын дүн үнэн зөв, шударга, бодитой байхад эерэг нөлөөтэй.

Шалгалтыг зөвхөн 0, 1, 2, 3 гэх мэт бүхэл оноогоор дүгнэнэ. 0.5, 1.5, 2.5 гэх мэт бутархай оноог ямар ч тохиолдолд өгөхгүй.

Оноо өгөх зарчим:

Даалгавар 1. Нийт 2 оноо

Эхэд дэвшүүлсэн асуудлыг зөв тодорхойлсон бол 2 оноо

Эхэд дэвшүүлсэн гол асуудлыг олоогүй ч тодорхой хэмжээнд хөндсөн асуудлыг олсон бол 1 оноо

Эхэд дэвшүүлсэн асуудалтай хамаагүй зүйл олсон эсвэл асуудлыг тодорхойлоогүй тухай гэж ерөнхийлсөн бол 0 оноо /Цөөхөн үлдсэн мазаалайг хамгаалах тухай гэх биш мазаалайн тухай эм хариулт нь ерөнхий болно/

Даалгавар 2. Нийт 3 оноо

Эхийн гол санааг илэрхийлсэн өгүүлбэрийг олсон бол 2 оноо

Эхийн гол санааг илэрхийлсэн өгүүлбэрийг олсон боловч, өөр өгүүлбэр хамт бичсэн эсвэл цогцолбороор нь авсан бол 1 оноо

Эхийн гол санааг илэрхийлэх өгүүлбэрийг олж чадаагүй бол 0 оноо

Эхээс эш татан санаагаа батлан тайлбарласан бол 1 оноо

Гол санааг буруу тайлбарласан эсвэл эхээс эш таталгүй, өөрийн үгээр бичсэн бол 0 оноо

Даалгавар 3. Нийт 2 оноо

Үзэл бодол нь дэвшүүлсэн асуудалтай уялдаа холбоотой бол 1 оноо

Үзэл бодол нь дэвшүүлсэн асуудалтай холбоо хамааралгүй бол 0 оноо

Үзэл бодлоо илэрхийлэх үгсийг ашигласан бол 1 оноо

Үгсийг ашиглаагүй бол 0 оноо /Мөн даалгавар 1-ийг гүйцэтгэлгүй орхиж энэ даалгавар /Даалгавар 3/-ыг хийсэн бол энэ даалгаврыг бүхэлд нь 0 оноо/

Даалгавар 4. Нийт 3 оноо

Даалгавар 3-т бичсэн үзэл бодолтой хамааралтай бол 1 оноо

Ахин нэг өөр байр сууринаас хандсан бол 0 оноо /хэрэв энд 0 оноо авсан бол баримтыг зөрчилтэйд тооцно/

Өөрийн үзэл бодлыг дэмжсэн, баталсан буюу зөрчилгүй бол 1 оноо

Аль нэг баримт зөрчилтэй бол 0 оноо /өөрийн үзэл бодлын эсрэг, ташааруулж болох, худал зэрэг баримтууд нь зөрчилтэйд тооцогдоно/

Гурван баримт бичсэн бол 1 оноо

Нэг л баримт дутуу бол 0 оноо /Мөн даалгавар 1, 3-ыг гүйцэтгэлгүй орхиж энэ даалгавар /Даалгавар 4/-ыг хийсэн бол энэ даалгаврыг бүхэлд нь 0 оноо/

Даалгавар 5. Нийт 3 оноо

Даалгавар 3, 4-ийг хамааруулан нэгтгэн дүгнэсэн бол 1 оноо

Дүгнэлт нь тодорхой бөгөөд ойлгомжтой бол 1 оноо

Дүгнэлтээс асуудлыг шийдэх ямар нэгэн шийдэл, гарах арга зам эсвэл шинэ санаа гарсан бол 1 оноо

Дээрх шалгуурын аль нэгийг хангаагүй тохиолдолд харгалзах оноог хасна. Мөн даалгавар 1, 3, 4-ийн аль нэгийг гүйцэтгэлгүй орхиж энэ даалгавар /Даалгавар 5/-ыг хийсэн бол энэ даалгаврыг бүхэлд нь 0 оноо

Даалгавар 6. Нийт 2 оноо

Өгүүлбэрийн найруулгын алдааг бүрэн төгс зассан бол 2 оноо

Өгүүлбэрийн найруулгын алдааг дутуу хагас зассан бол 1 оноо

Найруулгын алдааг засаагүй, буруу зассан эсвэл өөр шинэ алдаа гаргасан бол 0 оноо

Даалгавар 7. Нийт 5 оноо

Бүгдийг зөв хөрвүүлсэн бол 5 оноо

1-2 үг алдаатай хөрвүүлсэн бол 4 оноо

3-4 үг алдаатай хөрвүүлсэн бол 3 оноо

5-6 үг алдаатай хөрвүүлсэн бол 2 оноо

7-8 үг алдаатай хөрвүүлсэн бол 1 оноо

9 ба түүнээс дээш үг алдаатай хөрвүүлсэн бол 0 оноо

Даалгавар 8. Нийт 20 оноо

агуулаа	оноо өгөх заавар	ОНОО
Сэдэв ба зорилго	Зорилгоо хангаж, эхийг бүхэлд нь учир шалтгааны уялдаа холбоотой бичсэн бол	5
	Учир шалтгааны уялдаа холбоо, цаг хугацаа, үйл явдлын дараалал бага зэрэг алдагдсан бол	4
	Учир шалтгааны уялдаа холбоо муутай ч сэдвийн дагуу бичсэн бол	3
	Сөрөг хандлагатай эсвэл нэг үйл явдлыг биш хэд хэдийг бичсэн бол	2
	Ямар нэгэн зохиол бүтээлээс санаа авсан, санааг давтсан бол	1
	Сэдэв, зорилгоос хазайсан, хуулсан бол	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Дүр дүрслэл	Дүр, дүрслэлийг оновчтой ашигласан бол	2
	Оновчтой биш ч дүрслэх ур маяг ашигласан бол	1
	Дүрслэх ур маяг ашиглаагүй, хүний хэлсэн үг зэрэг нь ялгарч мэдэгдэхээргүй бол	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Хэв маяг	Эх бүхэлдээ хүүрнэсэн өнгө аястай бол	2
	Эхийн ихэнх хэсэг хүүрнэсэн бол /дүр, орчноо танилцуулах гээд хэт их тоочих зэрэг алдаа гарсан бол/	1
	Эх бүхэлдээ өөр хэв маягтай бол	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Бүтэц	Эхийн бүтэц ойлгомжтой, догол мөр, зайгаар заагласан бол	3
	Эхийн бүтэц ойлгомжтой хэдий ч догол мөр зайгаар зааглаагүй бол	2
	Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгийн аль нэг нь дутуу бол	1
	Эхийн бүтэц тодорхой зааггүй, санаа бүрэн биш бол	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Хэл зүй, найруулга	Хэл зүй найруулгын алдаагүй бол	3
	Хэл зүй найруулгын багахан алдаатай ч ерөнхий цогцолбор болоод бичвэрийнхээ найруулгад нөлөөлөөгүй бол	2
	Хэл зүй найруулгын алдаа нь тухайн цогцолбор болоод бичвэрийнхээ найруулгыг сулруулсан бол	1
	Хэл зүй найруулгын алдаа их бол /4+ алдаа/	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Үгийн тоо	180-210 хооронд бол	1
	Үгийн тоо их, бага бол	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Зөв бичгийн дүрэм	0-1 алдсан бол	3
	2-5 алдсан бол	2
	6-9 алдсан бол	1
	10+ бол	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Бичгийн соёл	Уншиж ойлгоход саадгүй бол /дармал байж болно/	1
	Уншиж ойлгоход хэцүү, үсэг, тэмдэг хооронд ялгаагүй бичсэн бол.	0
	<i>хийгээгүй бол</i>	X